

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ
ХИЙХ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	2
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	3
АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох.....	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	5
1.3. Шалгуур үзүүлэлтийг тогтоох	6
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	8
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	11
2.1. Хууль эрх зүйн орчин	11
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	32
3.1. Дүгнэлт.....	32
3.2. Зөвлөмж	34
ХАВСРАЛТ	36
Хуулийн төслийн үзэл баримтлал	37
Хуулийн төсөл.....	41
Хуулийн төслийн танилцуулга.....	50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНТХ	Ахмад настны тухай хууль
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
УДШ	Улсын Дээд Шүүх
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлог	6
Хүснэгт 2. Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлог	8
Хүснэгт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл	18
Хүснэгт 4. Эмч, сувилагч, ахмадын кабинетын судалгаа	23
График 1. МУ-ын хүн амын нас баралт 2020-2021 он	14
График 2. Ахмад настны насны хишиг	16
График 3. МУ-ын ахмад настны амьжиргааны түвшин	17
График 4. МУ-ын ахмад настны амьжиргааны түвшин	18
График 5. Эмч, сувилагч, ахмадын кабинетын судалгаа	24

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Ахмад настны тухай хуулийн (цаашид АНтХ гэх) хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “жишиг үнэлгээ” хийв.

Үнэлгээ хийх ажлыг УИХ-ийн гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболдын захиалгаар Өмгөөллийн “Юзисан партнерс” ХХН гүйцэтгэгч хэрэгжүүлэгчээр ажиллаа.

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь АНтХ зорилгодоо хүрсэн түвшнийг тогтоох, цаашдын нөлөөлөл, нийгэмд үзүүлэх үр дагаврыг илрүүлэн гаргахад чиглэгдэнэ.

Үнэлгээний ажлын зорилт нь АНтХ-ийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хэрэгжилтийн байдалд нь бодит дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Төлөвлөсний дагуу үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дараах алхмуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлсон;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоосон;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоосон;
- Харьцуулах хэлбэрийг сонгосон;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгосон.

Үнэлгээний төгсгөлд үр дүнг холбогдох салбарын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлж, онол-практикийн хурал зохион байгуулна.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Хууль нь тухайн төрлийн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажил эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох шаардлагатай байсан. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэлгээ хийж болно. Өөрөөр хэлбэл, энд заасан нөхцөл байдлаас өөр үндэслэл, шалтгаанаар хууль болгоны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагагүй гэсэн үг юм.

Монгол Улс нийгмийн халамжийн багц хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, АНтХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдаж, тухайн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байдаг. Уг хуулийг батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдаж 2024 оны 01 дүгээр саарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон, мөн хуульд заасан бусад харилцааг зохицуулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудтай уялдуулан 2021 оны 12 дугаар сарын 16-нд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, 2022 оны 04 дүгээр сарын 22-нд ахмад настанд үзүүлэх дэмжлэг, ахмад настны ашиг сонирхлыг төлөөлөн хэрэгжүүлэх төрийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэг зэрэг харилцаанд өөрчлөлт орсон байна.

АНТХ нь зөвхөн нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж байсан урьдах хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл хүртээмжийг сайжруулах, ахмад настны нийгмийн хамгааллын талаар урд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшнийг сайжруулсан, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг нэмж тусгаснаараа олон улсын байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцсэн бодлогын чухал баримт бичиг болсон. Мөн ахмад настантай холбоотой үйл ажиллагааг зохицуулсан Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиуд үйлчилж байна.

Эдгээрээс гадна Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг төрөөс баталсан бодлогын баримт бичгүүдэд ахмад настны эрхийг хамгаалах асуудлыг тодорхой хэмжээнд тусгажээ.

Энэхүү хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд ахмад настныг нийгмийн идэвхтэй гишүүн байх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл насжилтыг дээдлэх, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж, тэдгээрийг хэрэгжүүлж ирсэн ч ахмад настны өмнө тулгарч буй олон асуудлууд шийдлээ хүлээсээр байна.

Үнэлгээ хийх шалтгаан болон хүрээг тогтоохын тулд бид эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, эрдэмтэд, судлаачид болон хуулийн хэрэгжилтэд өртөж буй этгээдүүдийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан эмхэтгэл, статистик тоон мэдээлэл, олон улсын байгууллага, сангаас гаргасан судалгааны тайлан, санал зэргийг уншиж судлан жирийн иргэд, эрх зүйчдээс анкетын аргаар санал асуулга авах, эрх бүхий ажил, албан тушаал эрхэлж буй зарим хүмүүстэй уулзаж ярилцах, зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажил нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдэнэ. Түүнчлэн энэхүү алхам нь үнэлгээ хийх шалтгаантай шууд уялдаатай байх шаардлагатай.

Үнэлгээ хийхэд хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд хамгийн их нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалт /бүлэг, зүйл, заалт/-ыг тусгайлан сонгосон. Үнэлгээ хийх хүрээг урьдчилан тогтоосноор зарим зохицуулалт орхигдох эсхүл буруу тодорхойлогдох нөхцөл байдал үүсэж болзошгүй бөгөөд ийм байдал ажиглагдвал дахин шалгаж, залруулах болно.

Тухайн үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо ахмад настны нийт хүн амд эзлэх хувь, тэтгэвэр авагчдын наслалт, тэтгэврийн доод болон дундаж хэмжээ, зарцуулсан хөрөнгө, өрхийн орлогын хүрэлцээ, инфляцын түвшин, нийгмийн халамжийн үйлчилгээ болон түүний төрөл, нэмэлт хөнгөлөлт, өвчлөл, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх, хөгжих, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх эрх, дэлхийн улс орнуудын туршлага зэргийг судлан, эдгээр асуудлууд ахмад настны эрх зүйн байдалд хэрхэн хөндөгдөж байгааг олж тогтоон судалгаанд хамруулсан.

1.3. Шалгуур үзүүлэлтийг тогтоох

Үнэлгээний ажлыг төлөвлөх шатны гол тулгуур хэсэг нь тухайн үнэлгээг хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох алхам юм. Ингэхдээ дараах зургаан үндсэн шалгуур үзүүлэлтээс үнэлгээний хүрээтэй аль тохирохыг нь сонгож, тогтооно. Үүнд:

- зорилгод хүрсэн түвшин;
- зардлын өсөлт, бууралт;
- зардал, үр өгөөжийн харьцаа;
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- практикт нийцэж байгаа байдал;
- бусад үр дагавар.

Шалгуур үзүүлэлтийг сонгохын тулд шалгуур үзүүлэлт тус бүрийн ойлголт, онцлог, хоорондын ялгааг харгалзан үзэх нь чухал ба сонгосон шалгуур үзүүлэлт нь үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байхын гадна хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байх шаардлагатай байсан.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлог

Д/д	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Жишээ тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.	АНТХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдаж, тухайн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Хууль санаачлагч хуулийн үндсэн зорилгыг “ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж тодорхойлсон. Хуульд үндсэн зорилгоос гадна бүлэг, хэсэг, зүйл бүрт тодорхойлсон дагалдах зорилго байж болох бөгөөд үүнийг давхар шалгасан болно.

2	Зардлын өсөлт, бууралт	Хууль хэрэгжсэнээр үүсэж байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно.	АНТХ хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүссэн зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно. Үүнд, санхүүгийн, хүний нөөцийн, техникийн гэх мэт олон зардал хамаарна. Гэхдээ энэ хэсгийг үнэлэхдээ зөвхөн тухайн үнэлгээнд хамааралтай, анхаарал татсан зардлыг авч үзсэн.
3	Зардал, үр өгөөжийн харьцаа	Хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, гарсан үр өгөөжийн харьцааг тооцон гаргана.	АНТХ-ийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр өгөөжийн харьцааг тооцон гаргана. Хуулийг хэрэгжүүлэхэд гарсан зардал нь, бий болсон үр өгөөжөөсөө өндөр байх, ийм зардал гаргаснаар хуулийн зорилгодоо хүрээгүй, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлээгүй тохиолдолд хуулийг цаашид хэрэгжүүлэх эсэх дээр эргэлзээ үүснэ.
4	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хүлээн авч буй байдал, хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлно.	АНТХ-ийн үр нөлөөг шууд хүртэж буй буюу хуулийн үйлчлэлд хамаарч буй этгээдүүдэд тус хууль хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг тодорхойлно.
5	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийг хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.	АНТХ-ийн ойлгомжтой байдал, хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлно.
6	Бусад үр дагавар	Урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тооцоолно.	АНТХ-ийн хэрэгжилтэд тооцох аргагүй, сөрөг үр дагавар үүссэн эсэхийг тодорхойлно.

Үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран эдгээр шалгуур үзүүлэлтээс нэг буюу хэд хэдийг сонгож болох дараах таван шалгуур үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
3. Зардал, үр өгөөжийн харьцаа;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Практикт нийцэж байгаа байдал.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр АНТХ-ийн бүх зохицуулалтын хувьд зорилго болон зорилтдоо хүрсэн түвшнийг үнэлнэ.

Ер нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судалдаг хамгийн чухал шалгуур үзүүлэлт нь “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт юм. АНТХ-ийн 1 дүгээр

зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.” гэж заасныг хэрэгжүүлэхэд энэ хуулийн зохицуулалт хангалттай үйлчилж чадаж байна уу үгүй юу гэдгийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтээр АНТХ-ийн хэрэгжүүлэхэд гарсан зардал нь бий болгосон үр өгөөжөөсөө их эсхүл бага байгааг тодруулах, мөн ийм зардал гаргаснаар хуулийн зорилгодоо хүрч байна уу, нийгэмд ямар нэг тодорхой үр нөлөө үзүүлж байна уу гэдгийг тодорхой болгох зорилгоор сонгон авч үнэлгээг хийв.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр АНТХ-ийн үр нөлөөг шууд хүртэж буй буюу хуулийн үйлчлэлд хамаарч буй этгээдүүдийн эрх ашгийг хөндөж байна уу? эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн хувьд зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх, тус хууль хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг тодорхойлно.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийг сонгож авсан нь АНТХ-ийг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл учирч байна уу, чиг үүргээ хэрэгжүүлэхэд эрх хэмжээ нь хүрэлцэж байна уу, үүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалт ойлгомжтой байна уу, ер нь уг хууль хэрэгжих бодит боломж бололцоо практикт байгаа эсэхийг тодруулах зорилготой.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Хүснэгт 2. Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлог

Д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараахтай буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.

4	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.
---	------------------	--

Үнэлгээ хийхэд АНТХ-аас сонгож авсан зохицуулалтуудыг **үнэлэхэд хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс** хойш болон **тохиолдол судлах хэлбэрээр** харьцуулан үнэлнэ. **Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш харьцуулах хэлбэрийн хүрээнд** АНТХ үйлчилж эхэлснээс хойш /2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс/ Ахмад настны эрх, үзүүлэх үйлчилгээ, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоог дэмжих, эрүүл мэндийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндэс хэрхэн бүрэлдэж боловсронгуй болсон, ямар ололт амжилт бий болсныг судалж тогтоох бол **тохиолдол судлах хэлбэрийн хүрээнд** сонгон авсан зохицуулалт гадаад улс оронд ямар байдлаар хэрэгждэг талаар тодруулах юм.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээ хийх хүрээ, шалгуур үзүүлэлт, сонгосон харьцуулах хэлбэр, томъёолсон шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан ямар мэдээлэл олж авахаа тодорхойлж, шаардлагатай материалыг цуглуулсан болно.

1. Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал
/Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс 2015 он/
2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын статистик
/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2019-2022 он/
3. Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ
/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны хүрээлэн 2018 он/
4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр
/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл 2021-2022 он/
5. Эрүүл насжилтын арван жил суурь нөхцөл байдлын тайлан
/Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2021 он/
6. Ахмад настны нийгэм, улс төрийн оролцооны судалгааны тайлан /Фридрих Эбертийн сан 2022 он/
7. Ахмад настны социал асуудал
/Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философийн хүрээлэн 2022 он/
8. Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй ахмад настны эрх, хамгаалал судалгааны тайлан
/Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс 2022 он/
9. Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хүртээмжийн судалгаа
/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2023 он/
10. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл
/Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс 2023 он/
11. “Шинэ сэргэлт : Ахмадын оролцоо”
/Үндэсний чуулганы зөвлөмж 2023 он/

Холбогдох субъектээс судалгаа авах: АНТХ-ийн үйлчлэлд хамаарах этгээдүүд, судлаачдаас анкетын болон ярилцлагын аргыг ашиглан судалгаа авах зэрэг болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Цуглуулсан материал, ярилцлага, асуулгын байдал, нийтлэл, санал, шүүмж, эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд хэлэлцүүлэгдсэн илтгэл, АНТХ-ийг анх боловсруулах болсон үндэслэл, шаардлага хэрэгцээг тодорхойлж, мөн хуулийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тогтоож, санхүүгийн жил бүрийн тайлан зэрэгт үндэслэн дараах үнэлгээг хийв.

2.1. Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн арван дөрөвдүгээр зүйлд “1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх тэгш этгээд байна.” гэж заасан бөгөөд арван зургаадугаар зүйлийн 5/-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;” гэсэн нь Үндсэн хуулиас салбарлан гарсан хуулиудад ахмад настны талаар баримтлах суурь зарчмууд юм.

Ахмад настнуудын амьжиргааны түвшин нь анх тогтоосон тэтгэврийн хэмжээнээс шууд хамаарч байгаа тул тухайн асуудлыг хамгийн түрүүнд Хөдөлмөрийн тухай хуулиас эхлэн асуудлыг хайж тогтоох зорилго дэвшүүлээ.

Үндсэн хуулиас салбарлан гарсан ахмад настантай холбогдох гол хууль болох Хөдөлмөрийн тухай хуульд ахмад настан хэмээх ойлголт нь хүн хөдөлмөрлөх, хуульд заасан насанд хүрсний дараа хөдөлмөрлөх хугацаандаа төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хугацаанаас хамааран нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авахтай холбоотой асуудлууд шууд уялдаа холбоотой.

Хөдөлмөрийн тухай хууль нь зөвхөн хөдөлмөр эрхэлж буй иргэнд үйлчлэхээс гадна тэдний тэтгэвэр тэтгэмжтэй холбогддог. Гэвч иргэд хөдөлмөр эрхэлж байгаа тухайн цаг мөчдөө л илүүтэй анхаарахаас бус тэтгэвэр тогтоолгох ирээдүй цагийн асуудлаа үл ойшоох хандлага түгээмэл байна.

Ажилтан ажил олгогчийн хооронд үүссэн нийгмийн даатгалтай холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна. Харин Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан /хамтын гэрээ/, /хөдөлмөрийн гэрээ/-ний зохицуулалт байгууллагууд дээр хангалтгүй төвшинд хэрэгждэг. Ажилтан ажиллаж байх хугацаандаа дээрх гэрээг байгуулдаггүй, байгуулсан ч хэрэгжүүлдэггүй, байдал нь эргээд тэтгэвэр тогтоолгох үед иргэнд ашиггүй байдлаар илэрдэг.

Мөн хуулийн 145 дугаар зүйлд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн тухай заалтуудыг оруулж өгсөн байдаг. Үүнд:

145.1. Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно.

145.2. Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

145.3. Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна хэмээн заажээ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагч тэтгэврийн даатгалд доор дурдсан хувь хэмжээгээр шимтгэл төлдөг.

- Ажил олгогчийн төлөх шимтгэл 8.5 хувь
- Албан журмын даатгуулагчийн төлөх шимтгэл 8.5 хувь
- Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл 11.5 хувь

Өндөр насны тэтгэвэр авах эрх нь шимтгэл төлсөн байвал зохих хугацаа, болзол зэргээс шалтгаалан хувь тэнцүүлэх, нэмэгдүүлэх зэргээр тогтоохоор тусгасан байсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд

Даатгуулагч нь нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-оос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болдог.

Өөрийн төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол мөн Газрын дор хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч хуульд заасан болзлыг хангасан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Нас хүрээгүй даатгуулагч шимтгэл төлөх хугацааг хангаад цаашид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөө зогсоосон байхад түүний уг насанд хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгон авах эрх нь хадгалагддаг. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн, нас нь хүрсэн даатгуулагч шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлж байна.

Өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас тус тус багагүй байна.

Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол даатгагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсан дараагийн сар дуустал олгож байна.

Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай шийдвэрийг 1997 оноос хойш 7 удаа гаргаж, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын 2015 оны 52 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээ болон цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай шийдвэр гаргасан боловч 2014 онд тогтоосон тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн хэмжээг хэвээр үлдээжээ. Өөрөөр хэлбэл: 2014 оноос өнөөдрийг хүртэл 9 жилийн хугацаанд тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоогоогүй байна.

2014 онд хөдөлмөрийн хөлсний цалингийн доод хэмжээ 192,000 төгрөг байсан бол 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 550,000 төгрөг болж 2.8 дахин, инфляц (хэрэглээний үнийн улсын индекс) мөн үеэс 2.8 дахин функтээр тус тус өссөн байна.

Эдгээрээс үзэхэд олон жилийн өмнө тэтгэвэр тогтоогдсон хүмүүсийн анх тэтгэвэр тогтоосон цалинг нь цалингийн өсөлттэй уялдуулсан индексээр өсгөж тэтгэврийг өөрчлөн тогтоогоогүй, мөн 2021 онд тэтгэврийг огт нэмээгүй зэргээс шалтгаалан тэтгэврийн зөрүү улам ихсэх үндсэн шалтгаан гэж дүгнэхээр байна.

Тэтгэврийн хэмжээ нь тухайн хүний авч байсан цалин хөлс, ажилласан хугацаанаас хамааралтай тогтоогддог учраас харилцан адилгүй байдаг. Тухайлбал: нэг ижил хугацаанд тэтгэврээ тогтоолгосон адил ажил мэргэжлийн хоёр хүний аль нь олон жил ажилласан буюу шимтгэл төлсөн мөн тэтгэврээ тогтоолгохдоо сонгосон сүүлийн 20 жилийн доторх дараалсан 84 сарын цалин нь өндөр байсан хүний тэтгэвэр өндөр тогтоогдоно. Хөдөлмөрийн үнэлэмж буюу цалин хөлсөнд гарсан өөрчлөлттэй холбоотойгоор тэтгэврийн хэмжээ ялгаатай тогтоогдох нь зүй ёсны асуудал юм.

2000 оноос өмнөх үед ажиллаж байсан үйлчлэгч, багш, эмч нар өнөөгийн эдгээр ажил мэргэжил, албан тушаалыг хашиж байгаад тэтгэвэрт гарсан хүмүүсээс бага тэтгэвэр авч байна. Тухайн үеийн ажил мэргэжил, албан тушаалын бага цалин хөлсийг одоогийн адил ажил, мэргэжлийн албан тушаалтны цалинд ойртуулах арга зам нь цалингийн итгэлцүүрийг /индекс/ шинэчлэн тогтоох замаар тэтгэврийн зөрүүг арилгах боломжтой гэж мэргэжилтнүүд дүгнэж байна.

Иймд тэтгэврийг зөрүүг багасгах, арилгах арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор бий болсон бөгөөд үүнд итгэлцүүрийн аргыг тогтмол хэрэглэх шаардлагатай байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй ахмад ажилчдаас эрэгтэйчүүд 59 нас хүртэл буюу ажиллах хугацаандаа нас барах магадлал 51.2 хувь, хэрэв тэтгэвэрт гарах хугацааг 65 гэж тооцвол тэтгэвэрт гарч чадалгүй нас барах магадлал 64.0 хувьд хүрнэ гэсэн тооцоолол гарсан.

Монгол Улсад хүн амын нас баралт 2021 онд 19.9 мянга байснаас, насны бүлгээр авч үзэхэд 12,775 буюу 64.2 хувь нь 55 ба түүнээс дээш насны иргэд бөгөөд 2005-2020 онуудад нас баралтын тал хувийг буюу 44.0-54.3 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна.




График 1. МУ-ын хүн амын нас баралт 2020-2021 он

Ахмад настны нас баралт өндөр үзүүлэлттэй байгаа нь тэд ажиллаж хөдөлмөрлөснийхөө үр шимийг хүртэж чадахгүй, тэтгэврээ авч амжихгүй нас барах эрдэлтэйг харуулж байна.

Одоогоор Монгол Улсад тэтгэвэр өвлөгдөх буюу “хуримтлал”-ын тогтолцоо бүрдээгүй байгаа нь тэд хөдөлмөр эрхлэх хугацаандаа нийгмийн даатгалын санд шилжүүлсэн шимтгэлийн үр шимээ бүрэн хүртэж чадахгүйд хүрч, улмаар шимтгэл нь тухайн сандаа үлдэж 546 байгааг судлаачид тэмдэглэжээ.

Гэтэл тэдний банк болон банк санхүүгийн байгууллагаас авсан тэтгэврийн зээл болон бусад зээл нь нас нөгчсөний дараа үр хүүхэд болон гэр бүлийн гишүүдэд өвлөгдөн үлдэж байна.

Ахмад настны тэтгэвэр өвлөгдөхгүй хэр нь авсан зээл нь өвлөгдөж буй асуудал анхаарал хандуулж, тэтгэврийн эрхийг шилжүүлэх замаар өр төлбөрийг нь төлөх боломжийг судлах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2020-2024)-т Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилт дэвшүүлсэн байна.

Мөн төрөөс “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүр суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих, “Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Иймд тэтгэврийн эрх шилжүүлэх тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтад “тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй

хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан бол тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооно”, мөн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно”, гэж тус тус заасны дагуу хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагч тэтгэврийн хэмжээгээ өөрчлөн тооцуулах боломжтой байдаг.

Хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн шимтгэлийг тооцохдоо Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна...” гэсний дагуу шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл: хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагч нь олсон орлогоосоо тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд нийт 9.5 хувийн шимтгэл төлдөг байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил тутмыг анх тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас 1.5 хувиар тооцож байгаа нь ахмад настны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Одоогийн тогтолцоогоор олон жил ажилласан хүмүүсийн сүүлийн жилүүдийг буулгаж боддог томъёоллоор (эхний 20 жилийг 2.25 хувиар тооцдог бол илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар) тэтгэврийн хэмжээг тооцдог.

Гэтэл хөдөлмөр эрхэлсэн цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлж, ажилласан хугацаа нь нэмэгдэж байхад анх өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс 1,5 хувиар тооцож тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байгаа нь хөдөлмөрийг үнэлэмжийг бууруулж, ахмад настны тэтгэврээ нэмэгдүүлэх, орлогоо сайжруулах амьдралын чанараа дээшлүүлэх боломжийг багасгаж байна.

Хөдөлмөрийн тухай болон Ахмад настны тухай хуулиар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа атал ахмад настны хөдөлмөрийн үнэлэмжийг бодиттойгоор үнэлэхгүйгээр багасгаж тооцож байна. Иймд хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагч ахмад настнууд одоо авч байгаа цалин хөлснөөс ажилласан жилийн нэмэгдлийг тооцуулж тэтгэврийн хэмжээгээ нэмэгдүүлэх хүсэлтэй байгааг анхаарч үзэх шаардлагатай байна.

Эдгээрээс үзэхэд ахмадуудыг бүхимдүүлж буй гол асуудал нь тэтгэврийн хэмжээ бага амьжиргаандаа хүрэлцэхгүй, мөн тэтгэврийн зөрүү үүссэн асуудлууд зонхилж байна.

Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн хүрээнд

Энэ хуульд Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-

1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулиар Алдар цолтой ахмад настнуудад мөнгөн тэтгэмж олгодог байсан ч 2021 оны 01 дүгээр сарын 01- ний өдрөөс зөвхөн дээр дурдсан үйлчилгээг үзүүлж байна.

Ахмад настанд үзүүлэх насны хишгийг 65-69 настай ахмадад 50,000 төгрөг, 70-79 настай ахмадад 80,000 төгрөг, 90 ба түүнээс дээш настай ахмадад 250,000 төгрөг жилд 2 удаа олгодог бөгөөд 2022 онд насны хишигт 168,201 ахмад настныг хамруулжээ.




График 2. Ахмад настны насны хишиг

Ахмад настанд үзүүлэх хүндэтгэлийг тухайн ахмадын ажиллаж байсан байгууллага нь, харьяалах аж, ахуйн нэгж байгууллага байхгүй ахмад настанд нийгмийн халамжийн сангаас хүндэтгэл үзүүлэхээр холбогдох хуульд заажээ.

Нийгмийн халамжийн сангаас харьяалах аж, ахуйн нэгж байгууллага байхгүй ахмад настанд жилд 2 удаа хүндэтгэл үзүүлж 10,000 төгрөг олгодог байна. 2019 онд 128,052 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн байна.

Харьяалах байгууллагагүй ахмад настны нэгдсэн бүртгэл судалгааг гаргахад хүндрэлтэй, үүнээс шалтгаалж халамжид хамрагдах ахмад настны тоо эрс ялгаатай гардаг нь нийгмийн халамжийн санд ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтоохдоо цэргийн жинхэнэ алба, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан нийт албан хаагчдад хамаардаг. Энэ хуулиар 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй цэргийн албан хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан 1 жилийг 6 сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцож тогтоодог.

Цэргийн алба хаагч нь нас харгалзахгүйгээр ажилласан жилээс хамааран тэтгэвэр тогтоолгож байгаагаас үүдэлтэйгээр 40 орчим насны тэтгэвэр авагчид олон байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж иргэний үндсэн эрхийг баталгаажуулсан. Түүнчлэн Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай зэрэг хууль тогтоомжоор ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхийг зохицуулж байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй, дараах иргэнд сар бүр олгож байна. Үүнд:

- Эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй ганц бие ахмад настан
- Эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнийг асарч байгаа иргэн

Нийгмийн хамгаалал нь хувь хүнд тулгарах эрсдэл, өвчин, осол гэмтэл, төрөлт, хөгжлийн бэрхшээл, нас баралт, насжилт, ажилгүйдэлтэй холбоотой асуудал юм. Энэ нь ядуурлаас урьдчилан сэргийлж, ядуу иргэдэд дэмжлэг үзүүлж, тэдний амьдралыг тогтворжуулж, орлогыг нь баталгаажуулан, эрүүл мэнд, асрамжийн тусламж үйлчилгээг багтаасан нийгмийн тусламж үйлчилгээг хүргэх тогтолцоо юм.




График 3. МУ-ын ахмад настны амьжиргааны түвшин

Монголын ахмадын холбооноос ирүүлсэн мэдээллээр (2022 оны 01 дүгээр сарын 01- ний өдрийн байдлаар) нийт ахмадуудын 16.7 хувь буюу 28.2 мянган ахмад настан амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч, 3,963 ахмад настан ганц бие, харж хандах үр хүүхэдгүй, 7,815 ахмад хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн өвчтэй, 18.4 мянган ахмад настан бусдын байнгын асрамжид байна.




График 4. МУ-ын ахмад настны амьжиргааны түвшин

Ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр эрхээ адил тэгш эдлэх ёстойг олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажуулсан төдийгүй эрхээ тэгш эдлэх боломжгүй, ялгаварлан гадуурхалтад өртөж болзошгүй, эрх нь зөрчигдөж буй зорилтот бүлэгт төрийн зүгээс тусгайлан анхаарч, холбогдох бодлого хөтөлбөрт тэдний эрхийг эдлүүлэх асуудлыг тусгаж хэрэгжүүлэхийг төрд үүрэг болгосон байдаг.

Эдгээр нийгмийн бүлгийн нэг хэсэг болох ахмад настануудад эрхээ эдлэхэд шаардлагатай нийгмийн хэрэгцээт үйлчилгээг авахад нь нэмэлт тусламж, дэмжлэг хэрэгтэй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настанд Ахмад настны тухай болон холбогдох хуульд үндэслэсэн 4 үндсэн чиглэлийн хүрээнд 10 гаруй нийгмийн халамжийн үйлчилгээ болон бусад нэмэлт хөнгөлөлт, тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эдгээр үйлчилгээг үзүүлэхдээ тэтгэмж авагчийн нас, хүйс, хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээл зэргийг харгалзан шаардлага хангасан ахмад настныг хамруулж, хуульд заасан мөнгөн тэтгэмж, хөнгөлөлтийг олгодог байна.

Хүснэгт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл

Нийгмийн халамжийн тэтгэвэр	Нийгмийн халамжийн тэтгэмж	Нийгмийн халамжийн үйлчилгээ	Нийгмийн хөгжлийн үйлчилгээ
Ахмад настны тэтгэвэр	Асаргааны тэтгэмж	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	Боловсролыг дэмжих үйлчилгээ
Эхийн алдар, одонгийн мөнгөн урамшуулал	Ахмад настанд үзүүлсэн тусламж үйлчилгээ	Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	Насны хишиг

Нийгмийн халамжийн тэтгэврийн хувьд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрх үүсэхгүй байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох мөнгөн тэтгэмж бөгөөд сард 288,000 төгрөгийн тэтгэвэр олгодог байна.

Энэхүү тэтгэвэрт 2021 онд 4607 ахмад настныг хамруулж, 12,892,891.1 сая төгрөг зарцуулжээ. Тус тэтгэврийн хэмжээг 2020 онд нэмэгдүүлж, 144,000-288,000 төгрөг болгон тогтоосон боловч ахмад настны амьжиргааны наад захын хэрэгцээнд хүрэлцдэггүй байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд ахмад настанд чиглэсэн асаргааны, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих 2 төрлийн тэтгэмжийг олгож байна. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжээс байнгын асаргаа шаардлагатай ахмад настанд улиралд нэг удаа 60,000 төгрөгийн тэтгэмж олгох бөгөөд 2021 оны байдлаар 2,9 мянган ахмад настан байнгын асаргаанд байна. (Ахмад настныг асарч байгаа хүний тоог оруулаагүй болно.)

Байнгын асаргаанд байдаг дийлэнх ахмадын хувьд энэ мөнгөн тэтгэмж нь хүрэлцээгүй, эм тариандаа ч хүрдэггүй гэж хариулсан байна

Нийгмийн халамжийн үйлчилгээний хувьд ахмад настанд чиглэсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд улсын хэмжээнд 106 төрийн бус байгууллага олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг явуулж байна. Халамжийн үйлчилгээний зөвлөгөө өгөх, сэргээн засах, түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж зэрэгт 2021 онд улсын хэмжээнд 2200 ахмад настныг хамруулж, 170,621,080 төгрөг зарцуулжээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах нийгмийн хэрэгцээ, ахмад настны тоо өндөр байгаа ч хүртээмж бага тул энэ төрлийн үйлчилгээг өргөжүүлэх шаардлагатай байна. Ахмад настанд өдрийн үйлчилгээ үзүүлэх, хамруулах байдал нь хот хөдөөд харилцан адилгүй байна.

Хөдөө амьдардаг ахмад настанд энэ төрлийн үйлчилгээг үзүүлж, хамруулахад нь нэлээд бэрхшээл тулгарч байна. Тухайлбал: Алслагдмал газарт амьдарч буй ахмад настануудад үйлчилгээг хүргэх боломж бага байна.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настанууд хамрагдаж байна.

Улсын хэмжээнд 12 асрамж үйлчилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 434 иргэн хамруулснаас 259 ахмад настан, 175 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна

Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, орон сууцны үнийн хөнгөлөлт, амралт сувиллын үнийн хөнгөлөлт, тээврийн хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнүүд багтаж байна. Энэхүү тусламж үйлчилгээнүүдэд 2022

оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 316,000 ахмад настан хамрагдсан байна.

Ахмад настнуудад насжилтаас үүдэлтэй өвчлөл, гэмтэлд өртөх эрсдэл их тохиолддог ч мэдээлэл дутмагаас протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй байна.

Дээрх үйлчилгээний мэдээллийг халамжийн байгууллагын цахим хуудас болон сум, дүүрэг, баг, хорооны мэдээллийн самбарт байрлуулдаг ч мэдээлэл хүртээмжгүй байна. Тиймээс эдгээр үйлчилгээний мэдээллийг зорилтот бүлэгт хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн оновчтой аргыг ашиглах хэрэгтэй.

Нийгмийн хөгжлийн үйлчилгээний хувьд ахмад настанд чиглэсэн боловсролыг дэмжих үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах хүнс тэжээлийн дэмжлэг гэсэн 3 төрлийн үйлчилгээ багтсан.

Ахмад настнуудад хоол хүнс худалдан авахад дэмжлэг үзүүлэх хүнсний үйлчилгээг хэрэгжүүлж байна. Монгол Улсад 60 ба түүнээс дээш насны ахмад настнуудын 84 хувь нь хоол тэжээлийн хувьд хэвийн, 14 хувь нь хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас олгож, боловсролыг дэмжих үйлчилгээний хувьд эрх зүйн орчин бүрдэж эхлээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хүрээнд

Хуульд зааснаар тэтгэврээс өөр орлогогүй иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлдөг. Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, амбулаторийн үзлэг, хяналт оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, өдрийн эмчилгээ багтана. Мөн эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийг эдлэх эрхтэй байна.

Үндэсний болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод зорилтот бүлгийн иргэдийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлэх, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын бүлгүүд, тухайлбал: эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгох, ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулах гэж тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газраас “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг 2019 онд батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 53.3 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг, 97 хувь нь

бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чаддаггүй, 85.5 хувь нь нэг буюу түүнээс дээш өвчнөөр өвдөж байна гэсэн шаардлагуудын улмаас улмаас батлагдсан байна. Мөн төрийн алба болон хувийн хэвшилд ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхах нөхцөл үүсэж байгааг хөтөлбөрийн үндэслэл болгожээ.

Хөтөлбөрт ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, чадамжийг дээшлүүлэх, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 58 зорилтыг өмнөө тавьж 2019-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хэдийгээр уг хөтөлбөр 2023 онд дуусахаар байгаа ч хэрэгжилтэд нь хийсэн ямар нэгэн дүн шинжилгээ, судалгаа хараахан олдоогүй.

Харин ахмад настны ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021 онд “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрт ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, аж ахуй болон өрхийн үйлдвэрлэлд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох гэсэн гурван чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр тусгажээ.

Ахмад настны тухай хуульд заасан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-нд тулгуурлан “Хүүхэд хамгаалагч төсөл” хэрэгжиж байгаа бөгөөд уг хөтөлбөр нь хүүхэд бүрийг гэрээс нь сургууль хүртэл, сургуулиас гэр хүртэлх замыг бүрэн хяналтад авч, тэднийг эрүүл, аюулгүй зорчиход дэмжлэг үзүүлж, хүүхэд бүрийг эрсдэлээс хамгаалах зорилготой бөгөөд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаалаар энэхүү төслийг хэрэгжүүлэх төсөв, хөтөлбөрийг баталжээ.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хүүхэд хамгаалагч төсөлд 2020- 2022 онуудад нийт 4,475 ахмад хамрагдаж 8,103,353.9 мянган төгрөг зарцуулж, 4516 иргэн ажлын байраар хангагдсан байна.

2020 онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 503 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 503 иргэн ажлын байраар хангагдаж, 225,113.7 мянган төгрөгийг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 381 ахмад хамрагдаж, 399 иргэн ажлын байраар хангагдаж, 764,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бол хүүхэд хамгаалагч төсөлд 233 ахмад хамрагдаж, 239,175.3 мянган төгрөгийг зарцуулж, 233 иргэн ажлын байраар хангагдсан.

2021 онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 560 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 561 иргэн ажлын байраар хангагдаж, 319,672.0 мянган төгрөгийг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 381 ахмад хамрагдаж, 417 иргэн ажлын байраар хангагдаж, 897,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бол хүүхэд хамгаалагч төсөлд 2021 онд 167 ахмад хамрагдаж, 194,766.0 мянган төгрөгийг зарцуулж, 167 иргэн ажлын байраар хангагдсан.

2022 онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 848 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 724 иргэн ажлын байраар хангагдаж, 707,482.5 мянган төгрөгийг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1,056 ахмад хамрагдаж, 1,166 иргэн ажлын байраар хангагдаж, 4,452,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бол хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 346 ахмад хамрагдаж, 346 иргэн ажлын байраар хангагдаж, 303,144.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газарт чиглэл хүргүүлсэн бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 онд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 6.9 тэрбум төгрөгийн төсвийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дээрх тоон мэдээллээс үзэхэд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо жил ирэх бүр өссөн дүнтэй байгаа нь ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн чухал алхам болсон байна.

Ахмад настны тухай хуулийн хүрээнд

Энэ хуулийн зорилт нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоожээ. АНТХ-д заасан хэрэгждэггүй, зөрчилтэй байгаа заалт нь ахмадын сангийн тухай асуудал байна. Төрийн байгууллага ямарваа нэгэн сан байгуулахыг төсвийн тухай хуулиар зөвшөөрөөгүй бөгөөд захиран зарцуулах эрх байгууллагын удирдлагад байдаггүй байна.

АНТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай” журмыг батлан гаргасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан мэдээгээр 2021 оны байдлаар улсын хэмжээнд 3,534 аж ахуйн нэгж, байгууллага “Ахмадын сан” байгуулан ажиллаж байна. Ахмад настны нийгмийн хамгаалал, хөгжил оролцоог дэмжихэд чиглэгдсэн ахмадын сан байгуулах аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн төсөв үйл ажиллагааны орлогоосоо цалингийн сангийн нийт 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр ахмадын сан байгуулж, ахмад настны нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, хөгжил, оролцоог нэмэгдүүлэх үүрэгтэй байна.

Үүнээс үзэхэд ахмад настны нийгмийн хамгаалал, хөгжил оролцоог дэмжихэд чиглэгдсэн ахмадын сан байгуулах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх тул аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн төсөв үйл ажиллагааны орлогоосоо цалингийн сангийн нийт 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр ахмадын сан байгуулах ажлыг эрчимжүүлж, ахмад настны нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, хөгжил, оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

АНТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцын өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ” гэж тус тус заажээ.

Гэвч Засгийн газар тэтгэврийн хэмжээг тогтоох талаар Ахмад настны тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан заалтыг хэрэгжүүлээгүйн улмаас тэтгэврийн зөрүү улам ихэсжээ. Тухайлбал: Өндөр насны тэтгэврийг 2010-2022 оны хооронд 12 удаа шинэчлэн тогтоожээ. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхдээ 2010-2021 оны хооронд 16,000-40,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 2022 онд Засгийн газрын 63 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500,000 төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400,000 төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Мөн тэтгэврийн зөрүүг арилгах, нэмэгдүүлэх нийгмийн шаардлагыг хэрэгжүүлэхдээ тэтгэврийн хэмжээг хуульд заасны дагуу итгэлцүүр (индекс) ашиглан инфляцын түвшинтэй үялдуулах замаар бус (механикаар) ижил хэмжээний мөнгөн дүнгээр нэмсэн нь зөрүүг бодитойгоор арилгаж чадаагүй байна. Иймд тэтгэврийн зөрүүг арилгалгүйгээр бүх тэтгэвэр авагчдад ижил хэмжээний нэмэгдэл олгох нь олон жил хөдөлмөрлөж, шимтгэл төлсөн ахмадууд үр ашгаа хүртэж чадахгүйд хүргэсэн байна.

АНТХ-д ахмад настны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ахмад настны кабинет, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд ахмад настны эмч, эсхүл ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, ур чадвар эзэмшсэн эмч ажиллуулахаар заасан.

Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын ахмад настны кабинетын үйл ажиллагааны статистик мэдээ дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Эмч, сувилагч, ахмадын кабинетын судалгаа

Нийслэл	Эмч	7	41%
	Сувилагч	3	20%
	Ахмадын кабинет	7	50%
Орон нутаг	Эмч	10	48%
	Сувилагч	1	50%
	Ахмадын кабинет	12	57%




График 5. Эмч, сувилагч, ахмадын кабинетын судалгаа

Дээрх судалгаанаас харахад хүний нөөцийн болон ахмадын кабинетын хүрэлцээ муутайгаас нийслэл болон орон нутагт ахмад настнууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авч чадахгүй байна.

Ахмадын эмч нь ахмадын бие даах чадвар, хоол тэжээл, сэтгэцийн байдал, сэтгэл гутрал зэрэг үзүүлэлтэд үнэлгээ хийдэг нарийн мэргэжил шаардсан чиг үүрэгтэй атал зарим эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд ахмадын насны доройтол, бие даах чадварыг нэгэнт эмчлэгдэхгүй гэдэг байдлаар хандах, ахмадын эмчийн хэрэгцээ шаардлагыг ойлгодоггүйн улмаас ахмадын кабинетыг татан буулгах, мэргэжлийн бус эмч ажиллуулдаг нь дээрх байдал үүсэхэд нөлөөлж байна.

АНТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт “Ахмад настан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авах эрхтэй...” гэж заахын зэрэгцээ сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв нь хэвтрийн болон архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг байнгын хяналтад авч, асран сувилах тусламж үзүүлэх явуулын үйлчилгээг ахмад эмч болон сувилагч, тусгайлан бэлтгэсэн сайн дурын ажилтныг оролцуулан зохион байгуулах, ахмад настны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ахмад настны кабинет, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд ахмад настны эмч, эсхүл ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, ур чадвар эзэмшсэн эмч ажиллуулахаар заасан.

АНТХ-ийн 10 дугаар зүйлд ахмад настны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төрөөс дэмжлэг үзүүлэхээр хуульчилсан. Эдгээр заалтын хэрэгжилт хангалтгүй, тааруу түвшинд буюу дунджаар 25 хувьтай хэрэгжиж байна.

Гэр хорооллын ахмад настнуудын зөвхөн 49 хувь буюу хоёр ахмад настан тутмын нэг нь хөнгөлөлттэй үнээр эм авах, 31 хувь буюу 3 ахмад настан тутмын нэг нь рашаан сувилалд амарч сувилуулах эрхээ эдэлж чадаж байна. Үүнээс гадна асран сувилах тусламж үйлчилгээ авах эрхийн талаар заасан ч эрхийн хэрэгжилт 7.8 хувьтай, хөл, гарын протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл авахад нийгмийн даатгалын сангаас нөхөн олговор авах талаар заасан ч эрхийн хэрэгжилт 12.1 хувьтай байгаа нь тус тус хангалтгүй байна.

Судалгаанаас харахад амралт сувилал, рашаан сувилал, сэргээн засах үйлчилгээнд хотын ахмадууд илүү их хамрагдаж байгаа нь мэдээлэл авах боломж, рашаан сувилалд хамрагдах боломж, санхүүгийн байдлаас их хамаардаг байна. Иймд ахмад настан бүрд мэдээлэл хүргэх сувгийг бий болгох, мэдээллийг энгийн ойлгомжтой байдлаар хүргэх, шаардлагагүй бичиг баримт шаардахгүй, аль болох шат дамжлага багатай зохион байгуулах шаардлагатай байна.

АНТХ-д заасан ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний төрөлд явуулын үйлчилгээ, өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим хэлбэрийг нийгмийн үйлчилгээтэй уялдуулж үзүүлэхээр хуульчилсан.

Энэ хүрээнд хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настныг сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвөөс өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын тусламж, үйлчилгээнд хамруулж буй боловч дээрх үйлчилгээний чанар хүртээмж, санхүүжилт хангалтгүй, ялангуяа гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын ажилтан, хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна.

Цаашид ахмад насны тоо өсөхийн хэрээр асаргаа шаардлагатай зорилтот бүлгийн ахмад настны тоо нэмэгдэх тул нийгмийн болон зорилтот бүлгийн эрүүл мэндийн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, Засгийн газраас урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтоо эрчимжүүлж асаргааны даатгалын хууль эрх зүйн орчныг нэн тэргүүнд бий болгох шаардлагатай байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэх эрх, бусдын адил цалин авах, биед нь харшлахгүй ажилд шилжүүлэх, АНТХ-д зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах, зээлийн дэмжлэг үзүүлэх, үргэлжлүүлэн ажиллуулах тухай зааж, ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих таатай нөхцөл бүрдүүлсэн боловч тэдний үнэлэмж, хөдөлмөр эрхлэх чадамж, бүлгийн онцлогт тохирсон ажлын байрыг дэмжих зэргээр хэрэгжилт нь хангалтгүй байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт туссан зөвлөх үйлчилгээ нь боловсрол бүхий ахмад настнуудад чиглэсэн, тэднийг багшлах, зөвлөх зэргээр оюуны ажил хөдөлмөр эрхлэх асуудлыг зохицуулсан нь тодорхой бүлгийн ахмад настнуудад чиглэсэн, мэргэжил, мэргэшлийн түвшнээс хамаарч хөдөлмөр эрхлэх боломжтой байхаар зохицуулжээ.

Чадварлаг бүтээлч ахмад ажилтнуудын үндэсний эдийн засгийн өсөлт үр ашгийг нэмэгдүүлэхэд оруулж буй хувь нэмэр нь нэмэлт ажлын байрыг бий болгодог учраас ахмадуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэх нь залуучуудын болон бусдын хөдөлмөрийн зах зээлийн боломжийг бууруулах үндэслэл болохгүй юм. Иймд ахмадуудын туршлага, ур чадварыг ашиглан залуучуудын шинэ хөдөлмөрийн нөөцийг бэлтгэх, сургахад тэднийг өргөнөөр ашиглах үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах нь зүйтэй юм.

Иймд Ахмад настны тухай хуулийг бүтээлчээр хэрэгжүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сүлжээ, бүртгэлийг улсын хэмжээнд бий болгон, ахмадуудын зөвлөх баг, хэсэг бүлэг байгуулж залуу мэргэжилтнүүдийг сургах, хамтран хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэх боломжийг тэдэнд нээн өгч байх асуудлыг жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийн сангаар дамжуулан хэрэгжүүлэх замаар ядуурал, ажилгүйдлийг бууруулж, ахмадуудын орлогыг нэмэгдүүлэх бодит арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Ахмад настны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор ахмад настныг ялгаварлан гадуурхах, дарамт хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн чухал зохицуулалтыг тусгасан байна.

Ахмад настан нь аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх бөгөөд АНТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад "ахмад настны эсрэг хүчирхийлэл" гэж аливаа этгээд ахмад настны эрх, эрх чөлөөг зөрчиж, түүний амь нас, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаанд гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгохоор тодорхойлсон бөгөөд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт "Ахмад настны өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тэтгэвэр, тэтгэмж, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглоно" мөн зүйлийн 6.10 дахь хэсэгт гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, түүнийг хөгжих, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглохоор тус тус заасан байна.

Мөн ахмад настан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, мөн хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг бусад гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдсэн байна. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих буюу гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан болон тэдний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан тохиолдолд шийтгэл оногдуулахаар заасан нь АНТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт хориглосон үйлдлүүдэд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлийг тодорхой хэмжээнд агуулсан байна.

2020 оноос 2022 оны байдлаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан ахмад настны эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл хавсарсан байдлаар сэтгэл санааны хүчирхийлэл 64 хувь, бие махбодын хүчирхийлэл 47 хувь, эдийн засгийн хүчирхийлэл 36 хувь, үл хайхрагдах байдал 21 хувь, бэлгийн хүчирхийлэл 0,1 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн хүчирхийлэлд өртөж буй гол хүчин зүйл нь тэтгэвэр, тэтгэмжийг нь зөвшөөрөлгүй зарцуулах, барьцаалж зээл авах, өмч хөрөнгийг нь дур мэдэн зарцуулах, ашиглах, үл хөдлөх хөрөнгийг нь өөрийн нэр дээр авах, байрнаас нь хөөх, хөрөнгөнөөс болж үр хүүхдүүд нь маргаж, сэтгэл санааг нь зовоох зэрэг асуудлууд байнга гарч байна.

Цаашид өсөн нэмэгдэж буй ахмад настны тоо болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх зэрэг зорилтот бүлгийн хэрэгцээ, хүйсийн ялгаатай байдалд нийцүүлж хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг төрөлжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид ялгаварлан гадуурхалтыг хориглосон ч хөдөлмөрийн харилцаанд ахмадууд ялгаварлан гадуурхалтад өртөх явдал цөөнгүй байна. Зарим аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газрууд ажлын байр зарлахдаа насны дээд хязгаарыг зааж өгдөг нь ахмад хүмүүс аль ч ажлын байранд ажиллах сонголт хомс байгааг харуулдаг. Энэ нь хөдөлмөрийн харилцаанд ахмад настай ажилтан чадваргүй гэх буруу ойлголт нийтлэг байгааг илтгэж байна.

Зөвхөн ахмад настай гэдэг шалтгаанаар ажлаас чөлөөлж, тэтгэвэрт гаргахыг урьтал болгохын зэрэгцээ асрамж, халамж хүсэгчид мэт хандах хандлага, үл хүндэтгэсэн харьцаанаас болж үл ойшоогдох, хэрэггүй, хэрэгцээгүй хүн болсон мэт санагдах, нийгмээс хаягдсан, тусгаарлагдсан мэдрэмж авч байгаагаас бусадтай харилцахаас зайлсхийх, санаа бодлоо илэрхийлэхийг тэвчих, сэтгэлээр унах, нийгмийн идэвх оролцоо нь буурах сөрөг үр дагавруудыг дагуулдаг байна.

Иймд насаар ялгаварлан гадуурхалтын эсрэг оновчтой бодлого хэрэгжүүлж, наснаас үл хамааран хувь хүнийх нь хувьд хүндлэх эрхэм чанарыг хүлээн зөвшөөрөх, ахмад залуу үеийн холбоог сайжруулах, ахмадын талаарх нийгмийн сөрөг хандлагыг өөрчлөх, энэ чиглэлээр үхуулан таниулах болон сурталчлах, ахмадын болон хүүхэд, залуучуудын байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна.

АНТХ-ийн 6 дугаар зүйлд нутгийн захиргааны байгууллага нь ахмад настанд биеийн тамир, спорт, соёл, урлагийн барилга, байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, биеийн тамир, спорт, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах, ахмадын баг, хамтлаг, клубийг үйл ажиллагаа явуулах байраар үнэ төлбөргүй хангах, тэдэнд зориулан чөлөөт цагаа өнгөрүүлэх танхим, мэдээллийн төвийг ажиллуулан сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө өгөх зэргээр хөгжил оролцоог нь дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлж өгчээ.

Энэ хүрээнд улсын хэмжээнд 441 ахмадын өргөө, танхим үйл ажиллагаа явуулж байгаа нь ахмад настныг хөгжүүлэх анхдагч суурь нөхцөл болж байна.

Гэвч зарим аймаг, сумын ахмадын төвийн байр чанар, стандартын шаардлагад нийцээгүй, байршлын хувьд хүртээмжгүй, тохижилт муу, тав тухгүй, чанарын шаардлага хангахгүй байгаа нь ахмадуудын идэвхтэй амьдрах, бүлгээр ажиллах, хөгжих боломж, орчин нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна.

Ажил эрхэлдэг, тэтгэврээс өөр нэмэлт орлоготой, бусдын дэмжлэг туслалцаа шаардлагагүй, аливаа хэлбэрийн гишүүнчлэлтэй, боловсролын түвшин өндөр, эрүүл мэнд нь харьцангуй сайн ахмадууд нийгмийн оролцоо илүү сайн байна. Харин хувь хүний болон нийгмийн, орчны хүчин зүйлсээс шалтгаалж ахмад настны оролцоо буурч байна.

Ахмадуудад ээлтэй орчин, аюулгүй дэд бүтэц бүрдээгүй, чимээ шуугиан ихтэй, явган хүний зам эвдрэл гэмтэл, халтиргаа гулгаа ихтэй, мөн гадна орчин тоосжилтой зэрэг тав тухгүй байдал нь ахмадын нийгмийн идэвх оролцоонд багагүй нөлөөлж байна.

Иймд ахмад настны хөгжил оролцоонд саад учруулж буй дээрх хүчин зүйлүүдийг арилгах ялангуяа ээлтэй, аюулгүй таатай орчин нөхцөл бүрдүүлэхийг чухалчлах, хуучин барилга байгууламж, дэд бүтцийн саадыг арилгах, шинээр бүтээн байгуулалт хийхдээ зорилтот бүлгүүдийн онцлог хэрэгцээг хангах чанар стандартад нийцсэн орчин нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.

АНТХ-ийн 7, 9, 10, 14 дүгээр зүйлийн зарим заалтуудад "... аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, ахмадын байгууллага нь сургалт зохион байгуулах", "хөдөлмөр эрхлэхийг дэмжих, жижиг зээл олгох зэрэг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах", "... сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв нь ахмад настанд зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, сургалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулах", "... Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн сургалт үйл ажиллагааг зохион байгуулах", "... Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны хэрэгцээ, сонирхлыг үндэслэн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, шинэ ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах, насан туршийн боловсролын үйлчилгээнд хамруулах талаар бодлого, төсөл, сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх" талаар үүрэг хүлээсэн байна.

ХЭҮК-ын судалгаанд оролцогчдын 81 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд өөрийгөө хөгжүүлэх сургалт, дамжаанд хамрагдаагүй гэж хариулжээ. Энэ нь сургалт зохион байгуулахаар үүрэг хүлээсэн дээрх байгууллагуудын сургалтын хамрах хүрээ бага, хүртээмжгүй, зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Сургалт дамжаанд хамрагддаггүй гэж хариулсан ахмадуудын тухайд нас өндөр болсон тул шаардлагагүй гэж 36.7 хувь нь, мэдээллийн хүртээмжгүй байдал гэж 23.1 хувь нь, төлбөрийн боломжгүй байдал гэж 22.0 хувь нь, сургалтын хүртээмж муу гэж 9.8 хувь нь хариулжээ. Ялангуяа, хотын зах болоод алслагдмал гэр хорооллын ахмадуудын хувьд ойр орчимдоо сургалтад хамрагдах боломж хязгаарлагдмал, чадавх эзэмших сургалтуудын төлбөр өндөр байна гэж хариулсан байна.

Үүнээс үзэхэд ахмад настнууд хувь хүний, нийгмийн, орчны хүчин зүйлээс шалтгаалж нийгмээс өөрийгөө тусгаарлах хандлага байна. Тухайлбал: судалгаанд оролцогчдын 38.5 хувь нь сургалтад хамрагдаж хэрэгцээ их, 35.9 хувь нь бага, 25.6 хувь тийм хэрэгцээ байхгүй гэж хариулжээ. Энэ нь нэг талаас ахмад настны талаарх

нийгэмд тогтсон буруу хандлага, үе хоорондын ойлголт, зөрчлөөс үүдэлтэй байж болзошгүй юм. Нөгөө талаар ахмадуудад хүргэх мэдээлэл, сургалтуудын хүртээмжтэй байдлыг сайжруулах хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Цаашид ахмад настнуудад чиглэсэн цахим үр чадвар, технологи ашиглах үр чадварыг нэмэгдүүлж, дижитал орчинд сургалт зохион байгуулах боломжийг бий болгох шаардлагатай байна. Мөн ахмадуудын хөгжих оролцох боломжийг дэмжсэн сайн дурын оролцоонд суурилсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ахмад настны хөгжих бололцоог хангах нь зүйтэй юм.

“ШИНЭ СЭРГЭЛТ: АХМАДЫН ОРОЛЦОО” үндэсний чуулганы зөвлөмж

Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн 800 гаруй ахмадууд бид “**Шинэ сэргэлт: Ахмадын оролцоо**” үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн ивээл дор Төрийн ордны Их танхимд зохион байгуулж, ахмадуудын ахуй амьдралын нөхцөл байдал, ахмадуудын талаар төрөөс баримтлах бодлого, үр дүн, тулгамдаж буй асуудлууд, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд ахмад настны оролцоог нэмэгдүүлж, шинэчлэлд хүрэх бодлого, арга хэмжээний талаар хэлэлцэхэд 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулсан урьдчилсан хэлэлцүүлгүүдээс гарсан 146 саналын нэгтгэл болон чуулганд хэлэлцүүлсэн илтгэлүүд, төлөөлөгчдийн хэлсэн санал, тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар дэвшүүлж буй саналыг дэмжин **ЗӨВЛӨМЖ** гаргах нь зүйтэй гэж үзсэн.

Уг чуулганаас дараах зөвлөмжийг төрийн эрх барих дээд байгууллага, Засгийн газар, олон нийтэд чиглэн гарсан байдаг. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД:

- 1.Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан тэтгэврийг тогтмол нэмэгдүүлэх;
- 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгад ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт тусган батлах;
- 3.Ахмадад олон улсын жишигт нийцсэн хувийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;
- 4.Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 5.УИХ-д ахмад настны талаарх бодлогын уялдааг хангах чиг үүрэг бүхий лобби бүлэг байгуулах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ:

- 1.Ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх, залуучуудад ахмад настны сургаал, ажлын баялаг туршлагаас суралцуулах, ахмад настныг хүндэтгэн дээдэлдэг уламжлалт ёс заншлыг залуу хойч үед өвлүүлэхэд чиглэсэн нөлөөллийн аяныг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах;
- 2.Ахмад настны “идэвхтэй насжилт”-ын цогц стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

- 3.Ахмад настны урт хугацааны тусламж, хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлэх төвүүдийг аймаг, дүүрэг, сумдад байгуулж, орон нутгийн ахмадын байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- 4.Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах хүрээнд Геронтологийн үндэсний төвийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх;
- 5.Ахмад настны асаргаа сувилахуйн хүний нөөцийг хомсдолыг арилгаж, бүх шатны эмнэлгийг ахмадын эмч, сувилагчтай болгох, ахмад настанд хөнгөлөлттэй үнээр олгодог эмийн нэр төрөл, хөнгөлөлтийн хувийг нэмэгдүүлэх;
- 6.Ахмад настанд сэтгэл зүйн хувьд дасан зохицох чиглэлээр сургалт, зөвлөгөө өгөх, ахмад настны асаргаа, халамжийн мэргэжилтэн болон сайн дурын ажилтнуудыг бэлтгэх, тэднийг урамшуулах тогтолцоог бий болгох;
- 7.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг бодитой дэмжих, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгодог дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх;
- 8.Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, ахмадуудыг түрээсийн орон сууцанд хамруулах, төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэх
- 9.“Ахмадын сан”-ийн хөрөнгийг төсвийн зүйл анги болгон баталж, “Ахмад настны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах

НИЙСЛЭЛ, ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

- 1.Ахмад настны мэргэжлийн холбоо, зөвлөл, клубуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тодорхой төсвийг жил бүр батлан, санхүүжилт олгох;
- 2.Ахмад настны сэтгэл зүйн асуудлыг анхаарч, тэдэнд чөлөөт цагаа өнгөрөөх, нийгмийн амьдралд оролцох, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг Ахмадын хөгжлийн төвүүдээр үзүүлэх;
- 3.Нийт хүн ам болон ахмад настанд эрүүл насжилтын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг хороо, багийн өрхийн эмнэлгүүдийг түшиж тогтмол зохион байгуулах;
- 4.Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангах, үйлчилгээг сайжруулах, төсвийг нэмэгдүүлэх, амрах эрхийн бичгийн олголтын цахимжуулалтыг эрчимжүүлэх, боловсронгуй болгох;
- 5.Ахмадуудыг түрээсийн орон сууцанд хамруулах, төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх;
- 6.Харьяалалгүй ахмадыг сум, хороо, багууд бүртгэж, Ахмад настны тухай хуульд заасан хүндэтгэлийн арга хэмжээнд хамруулах болон бусад шаардлагатай хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;
- 7.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн ахмадуудад зөвлөгөө, хамгааллын үйлчилгээ үзүүлэх;
- 8.Орон нутгийн ахмадуудыг Улаанбаатар хотод нийтийн тээврээр саадгүй үйлчлүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох;

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД:

- 1.Ахмад настны ажил, амьдралын туршлага, чадварыг хүүхэд, залууст таниулах, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх, залуучуудад ахмад настны сургаал, ажлын

баялаг туршлагаас суралцуулах, ахмад настныг хүндэтгэн дээдэлдэг уламжлалт ёс заншлыг залуу хойч үед өвлүүлэхэд чиглэсэн аянд нэгдэн контент, нэвтрүүлэх бэлтгэн олон нийтэд хүргэх.

АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД:

1.Ахмадын чиглэлээр үйл ажиллагааг явуулж буй төрийн бус байгууллагууд ахмадын нийтлэг эрх ашгийг хамгаалж нэгдмэл байх;

2.Аж ахуйн нэгж, байгууллага бүр Ахмад ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.Ахмад настны тухай хуульд заасан “ Ахмадын сан”-г байгуулж, холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангах, харьяалах орон нутгийн захиргааны байгууллагад тайлагнах;

4.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжиж, цалин урамшуулал олгох.

ОЛОН НИЙТ, АХМАДУУДАД:

1.Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэхэд хамтран ажиллах, өөрсдийн мэдлэг туршлагаа хуваалцах;

2.Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэхэд залуу үедээ үлгэрлэж, эрүүл мэндийн эрт илрүүлэгт бүрэн хамрагдаж, эрүүл насжилтад бэлтгэх;

3.Залгамж хойч үеэ өв соёл, эрдэм боловсролыг дээдэлдэг, амьдрах арга ухаанд суралцаж хатуужсан, овог удам, эх орондоо үнэ цэнэтэй иргэн болж хүмүүжиж төлөвшихөд нь дэмжин тусалж байх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж энэхүү судалгаа хийгдэж тус дүгнэлт гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

3.1. Дүгнэлт

- Ахмад настны талаар төрөөс тухайлан хууль болон урт хугацааны хөтөлбөрүүдийг баталсан ч Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эрхийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байна. Иймд зорилтот бүлэг тэр дундаа ахмад насны онцлог байдал, тулгамдсан асуудал, эрх хамгааллыг нийгмийн эрэлт, судалгаа, Шинэ сэргэлт-Ахмадын оролцоо чуулганы зөвлөмжид үндэслэн шийдвэрлэж, Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байна;
- Ахмад настны талаарх нийгэм, эдийн засгийн нарийвчилсан судалгаа, статистик мэдээ дутмаг байна. Статистикийн үндэсний хорооноос ахмадуудын талаарх статистик мэдээллийг 5 жил тутамд гаргаж, ахмадуудын талаар олон нийтийн яриа хэлэлцүүлэг их хийгддэг боловч нарийн тоон мэдээллүүд ховор байгаа нь төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээнд сөргөөр нөлөөлөхөөр байна;
- Ахмад настуудын тэтгэврийн эрх үүсэхэд Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байснаас шалтгаалан тэтгэврийн хэмжээ хангалтгүй тогтоогддог. Хөдөлмөрийн тухай хуульд заасан хамтын гэрээгүй, хөдөлмөрийн журамгүй, байсан ч хэрэгжүүлдэггүйгээс тусгай нөхцөл болон бусад урамшуулал авдаггүй нь цалингийн хэмжээнд нөлөөлж байна;
- Ахмад настны эрхийг баталгаатай эдлүүлэхэд тэдгээрт чиглэсэн нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн цогц үйлчилгээний төрөл, хүртээмж хангалтгүй, тэдний хөгжих, хөдөлмөрлөх, ядууралд өртөхгүйгээр амьдрах боломж нөхцөлийг бодитойгоор бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна;
- Ахмадуудад төрөөс олгож буй тэтгэвэр хэрэгцээг нь хангаж чадахгүй байна. Үеийн Засгийн газраас тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг ч инфляцын өөрчлөлтийг харгалзахгүй, улс төрийн шинжтэй шийдвэр гаргадаг нь тэтгэврийн шударга бус зөрүүг үүсгэсэн байна;
- Монгол Улсын хувьд нийгмийн халамжийн зардал өндөр, хамрах хүрээ өргөн ч амьжиргааны түвшин доогуур иргэд буюу зорилтот бүлэгт чиглэсэн халамж, тусламжийн хэмжээ бага, бодлого нь нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хүрч чадахгүй байгаа тул халамжид хамааралгүй, амжилтыг урамшуулан дэмжсэн шинжтэй дэмжлэг, туслалцааг тусдаа хуулиар зохицуулж, халамжийн хуулиар зөвхөн зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг зохицуулах нь зүйтэй байна;
- Ахмадын сангийн талаар байгууллагууд үүрэг хүлээсэн хэдий ч төсвийн тухай хуультай уялдаагүйгээс хамааран хэрэгжилт хангалтгүй байна. Иймд төсвийн тухай хуулийн зарим зөрчлийг арилгах хэрэгтэй байна;
- Ахмад настны эрүүл мэндтэй холбоотой суурь судалгааг хийж, судалгааны үр дүнд тулгуурласан оновчтой арга хэмжээ авах, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийн үр нөлөөг бууруулах шаардлагатай байна;
- Хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настанд өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засах гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй

байдалд анхаарал хандуулж, Засгийн газраас урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтоо эрчимжүүлэх, асаргааны даатгалын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна;

- Ахмад настныг ажиллуулах байгууллагад дэмжлэг болох хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс ахмад настнуудын хөдөлмөрлөх эрхийн нөхцөл, боломж дутмаг байна. Тэдний чадамж, бүлгийн онцлогт тохирсон ажлын байрыг бий болгох, ахмадуудыг ажилд авч буй аж ахуйн нэгжийг татварын урамшууллаар дэмжих бодлого хэрэгжүүлэх боломжтой байна;

- Ахмад настан нь олон нийтийн газар болон хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлагдах, гэр бүлийн хүрээнд үл хайхрагдах, хүчирхийлэл дарамтад өртөх явдал байсаар байна. Ахмадууд ганцаардах, сэтгэл санаагаа хэн нэгэнтэй хуваалцахгүй удаан явсаар сэтгэл гутралд орох, нас өндөр болсон хэмээн өөрийгөө голох, нийгмээс өөрийгөө тусгаарлах тохиолдол өндөр байгаа нь тэднийг бусдын нэгэн адил эрхээ эдлэхэд саад учруулж байна;

- Ахмадууд санхүүгийн байдалдаа анхаарал хандуулж шүгэл үлээх нь бага байгаа хэдий ч тэтгэврийн хэмжээнд сэтгэл хангалуун бус байна. Иймд хөдөлмөрийн тухай хуульд болон ахмадуудын тэтгэвэр тогтоолтод дүн шинжилгээ хийж алдааг засаж сайжруулах шаардлагатай байна;

- Ахмад настны оролцоог дэмжих, бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцох, үр шимээс хүртэх эрхэд саад учруулж буй дээрх хүчин зүйлүүдийг арилгах, ялангуяа тэднийг нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, мэдлэг туршлагаа хойч үедээ өвлүүлэх, боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна;

- Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүнлэг ёсыг эрхэмлэн ахмад настныг халамжлах, хүмүүнлэг үйлсийг нэмэгдүүлэх оюутан залуусын сайн дурын үйл ажиллагааг дэмжих;

- УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 34-т “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг төслийн 2021 онд баталж түүнд “Ахмад настны тухай хуульд заасан насны хязгаарт хамаарахгүй байгаа цэргийн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын тэтгэмж олгохтой холбогдсон эрх зүйн зохицуулалтыг тусгах” зохицуулалт болон уг жагсаалтын 100-д заасан “Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тухай” хууль 2021 онд батлуулах ба түүнд “Ахмад настны тэтгэврийг орлогын олон эх үүсвэрээс бүрдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох, сангийн хөрөнгийг хөрөнгийн зах зээлд байршуулах замаар нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал, дэмжлэг болон зохицуулалтын орчныг олон улсын стандартад нийцүүлэх, бий болгох” талаар зохицуулахаар тусгасан зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Ахмад настны төрсөн хүүхэд их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуульд суралцахад сургалтын төлбөрөөс хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

- Цаг үеийн шинжтэй бөгөөд суурь хэрэгцээнд нийцэх төсөвт ачаалал бага үүсгэх боломжийг судалсан бөгөөд тэдгээртэй холбоотой хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулах талаар ажиллана.

3.2. Зөвлөмж

- Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эрхийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа нь зорилтот бүлэг тэр дундаа ахмад насны онцлог байдал, тулгамдсан асуудал, эрх хамгааллыг цогцоор шийдвэрлэх шаардлага үүссэн тул тухайн зүйл заалтуудад өөрчлөлт оруулж эрх үүргийг ижил түвшинд хуваарилах;
- Ахмад настны талаарх нарийн тоон мэдээлэл дутмаг байгаа нь төрөөс гарах шийдвэрт нөлөөлөхүйц байгаа тул уг асуудлыг хууль нэмж оруулах, зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах;
- Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан тэтгэвэр тогтоолгох үед тасралтгүй НДШ төлсөн иргэд бага, цалингийн хэмжээнд нөлөөлдөг зэрэг нь тэтгэвэр тогтоолгоход хүндрэл үүсгэж байгаа тул уг хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх арга механизмыг сайжруулах, Нийгмийн даатгалын хуульд уялдуулан өөрчлөлт оруулах;
- Ахмад настны нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн цогц үйлчилгээний төрөл, хүртээмж хангалтгүй байгаа нь тэдний хөгжих, хөдөлмөрлөх, ядууралд өртөхгүйгээр амьдрах боломж нөхцөлийг бодитойгоор бий болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Ахмадуудад төрөөс олгож буй тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхдээ инфляцын өөрчлөлтийг харгалзан үзэж байх, тэтгэврийн шударга бус зөрүүг арилгах талаар шат дараатай арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;
- Амьжиргааны түвшин доогуур иргэд буюу зорилтот бүлэгт чиглэсэн халамж, тусламжийн хэмжээ бага, бодлого нь нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хүрч чадахгүй байгаа нь халамжид хамааралгүй, амжилтыг урамшуулан дэмжсэн шинжтэй дэмжлэг, туслалцааг тусдаа хуулиар зохицуулах, халамжийн хуулиар зөвхөн зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг зохицуулах;
- Ахмадын сан байгуулах эрх зүйн орчин уялдаагүйгээс ахмадуудтайгаа эргэх холбоотой ажиллах, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн хууль, эрх зүйн уялдаа холбоог хангуулах;
- Ахмад настны эрүүл мэндтэй холбоотой судалгааг хийж, судалгааны үр дүнд тулгуурласан оновчтой арга хэмжээ авах, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийн үр нөлөөг бууруулах арга хэмжээ авах;
- Хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настанд өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засах гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй байдалд тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, асаргааны даатгалын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Ахмад настныг ажиллуулах байгууллагад дэмжлэг болох ахмадуудын чадамж, бүлгийн онцлогт тохирсон ажлын байрыг бий болгох, ахмадуудыг ажилд авч буй аж ахуйн нэгжийг татварын урамшууллаар дэмжих тогтолцоог бүрдүүлэх;
- Ахмад настан нь олон нийтийн газар болон хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлагдах , гэр бүлийн хүрээнд үл хайхрагдах, хүчирхийлэл дарамтад өртөх

явдлыг таслан зогсоох, соён гэгээрүүлэх алхмыг хийж хэвшүүлэх талаар хуульд нэмэлт оруулах;

- Төрөөс тэтгэвэр тогтоох журам, явц, тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхцөл байдлын тухай нэгдсэн дүн шинжилгээ хийж, шударга ёсыг тогтоох.

----- ооОоо -----

ХАВСРАЛТ

БАТЛАВ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ЭНХБОЛД**

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн арван дөрөвдүгээр зүйлд “1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, “2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх тэгш этгээд байна.”, арван зургаадугаар зүйлийн 5/-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;” гэж тус тус заасан.

Монгол Улс нийгмийн халамжийн багц хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн. Уг хуульд зааснаас бусад харилцааг зохицуулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудтай уялдуулан 2021 онд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, 2022 онд ахмад настанд үзүүлэх дэмжлэг, ахмад настны ашиг сонирхлыг төлөөлөн хэрэгжүүлэх төрийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэг зэрэг харилцаанд нэмэлт орсон.

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг төрөөс баталсан бодлогын баримт бичгүүдэд ахмад настны эрхийг хамгаалах асуудлыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 оны хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох, сангийн хөрөнгийг хөрөнгийн зах зээлд байршуулах замаар нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал, дэмжлэг болон зохицуулалтын орчныг олон улсын стандартад нийцүүлэх, бий болгох талаар тусгасан.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулиас салбарлан гарсан ахмад настантай холбогдох гол хууль болох Хөдөлмөрийн тухай хуульд ахмад настан хэмээх ойлголт нь хүн хөдөлмөрлөх, хуульд заасан насанд хүрсний дараа хөдөлмөрлөх хугацаандаа төлсөн

нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хугацаанаас хамааран нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авахтай холбоотой асуудлууд шууд уялдаа холбоотой.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Ахмад настны тухай хууль 2017 онд батлагдахдаа зөвхөн нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж байсан урьдах хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл хүртээмжийг сайжруулж, ахмад настны нийгмийн хамгааллын талаар урд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшнийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг нэмж тусгаснаараа олон улсын байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцсэн бодлогын чухал баримт бичиг болсон. Мөн ахмад настантай холбоотой үйл ажиллагааг зохицуулсан Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиуд үйлчилж байна.

Гэвч эдгээр хуулиудад туссан зохицуулалтууд нь тэтгэврийн зөрүү улам ихсэх, тэтгэврийн эрх шилжүүлэх тогтолцоо бүрдээгүй, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа атал хөдөлмөрийн үнэлэмжийг бодитойгоор үнэлээгүй, харьяалах байгууллагагүй ахмад настны нэгдсэн бүртгэл судалгааг гаргахад хүндрэлтэй, нийгмийн хэрэгцээт үйлчилгээг авахад нь нэмэлт тусламж дэмжлэггүй, ахмадын сан байгуулах хуулийн хэрэгжилт хангалтгүй, рашаан сувилалд үйлчлүүлсэн нөхөн олговор зөрүүтэй, насны хишиг олгох насны хязгаар бусад хуультай нийцээгүй, инфляцын түвшинтэй уялдаагүй, асаргаа шаардлагатай ахмадын асран хамгаалагчийн асуудал хөндөгдөөгүй, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлага тодорхой бус байна.

Ийнхүү Ахмад настны тухай хуулийн нэр томьёо, ахмад настны эрх, эрүүл мэнд, тэдгээрт үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлага зэрэг харилцаанд хүндрэл учирч байгаа тул хууль, эрх зүйн шинэ орчин бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ахмад настны тухай хуулиар зохицуулж байгаа харилцаанд орхигдсон болон нийгмийн хэрэгцээ шаардлагаас урган гарч байгаа асуудлуудыг тусган Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Ахмад настны тухай хууль нь 4 бүлэг, 17 зүйл, 63 заалтаас бүрдэж байна.

Ахмад настны тухай хуулийн зорилт нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн

болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Нэгдүгээр бүлэгт ахмад настны хууль тогтоомжийн бүрдэл хэсэгт орхигдсон хууль тогтоомжийг нэмэх, жам ёсны эрхийг хангах үүднээс тэтгэвэр барьцаалсан зээлтэй нас барсан ахмад настны зээлийн эргэн төлөлт, тэтгэвэр тогтоолгоод удалгүй нас барсан ахмад настны тодорхой хувийг өв залгамжлагчид олгох асуудал, эдгээрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоох харилцааг тусгана.

Хоёрдугаар бүлэгт ахмадын асрамжийн үйлчилгээ үзүүлэх болон шинээр байгуулах аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, хэрэгцээ шаардлагад тулгуурлан аль нутаг дэвсгэрт байгуулах харилцааг тусгана.

Мөн Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх, төрийн албанд ахмад настны ур чадварыг харгалзан ажиллуулах, ажлын байрны ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, эрүүл мэндийг хамгаалах үүднээс асаргаа шаардлагатай ахмад настны асран хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох зохицуулалтыг тусгана.

Түүнчлэн ахмад настанд үзүүлэх дэмжлэг, насны хишиг авах эрх 65 наснаас үүсэж байгаа зохицуулалтыг бусад хуультай нийцүүлэх, дэмжлэгийн хувь хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулах харилцааг боломжит байдлаар тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт ахмад настны тоон мэдээлэл хангалтгүй байдгаас шалтгаалан тэнд хүрч үйлчлэх үйлчилгээ дутмаг байгаа асуудал, төрөөс гарах шийдвэр, түүнд хяналт тавих тогтолцоог сайжруулах талаар тусгана.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасан ахмадын сан байгуулан ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, бусад хуультай зөрчилдөж байгаа асуудлыг нийцүүлэн тусгана.

Мөн ахмад настны хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөж буй асуудлыг шийдэх зорилгоор соён гэгээрүүлэх, боловсролын хөтөлбөрт тусгуулах, эдгээр үйл ажиллагааг явуулах байгууллагын чиг үүргийг тодорхойлохоор тусгана.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд асаргаа шаардлагатай ахмад настны асран хамгаалагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар, тэтгэвэр барьцаалсан зээлтэй болон тэтгэвэр тогтоолгоод удаагүй нас барсан ахмад настны тэтгэврийг өвлүүлэх санхүүжилтийн асуудлыг тусгана.

Нийгмийн халамжийн тухай хуульд ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэх шинээр байгуулагдсан байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх санхүүжилтийг тусгана.

Төрийн албаны тухай хуульд ахмад настны ур чадварт тохирсон ажлын байраар хангах, хөдөлмөрлөх эрхийг нээх байдлаар зохицуулна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байхаар тусгана.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төрөл, ангилалд “Ахмадын сан” байгуулах эрхийг нээж өгөх замаар тусгана.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэхээр шинээр байгуулагдсан байгууллагад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах харилцааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна. Үүнд:

Ахмад настанд олгох тэтгэвэр, үзүүлэх дэмжлэг, тусламжийн хэлбэрийг өргөжүүлж, нас барсны дараах тэтгэвэр барьцаалсан зээлийн эргэн төлөлт мөн өв залгамжлагчид үлдэх тэтгэврийн хувь хэмжээг тогтоосноор ард иргэд өрийн дарамтаас гарах, амьжиргаа сайжрах, насаараа хөдөлмөрлөсөн хөдөлмөрийн үр шимийг гүйцэд хүртэх эерэг нөлөөтэй.

Ахмадын асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага шинээр байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих чиглэлээр хуульд нэмэлт оруулснаар ахмад настны нийгмээс ялгаварлан гадуурхагдах, хүчирхийлэл, дарамтад өртөх байдал арилж, эрүүл, урт наслах боломж нэмэгдэнэ.

Ахмад настны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны эрх үүргийг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгосноор ахмад настны нийгэмд эзлэх байр суурь баталгаажиж, залуу хойч үеийг амьдрах ухаанд суралцуулах, хүмүүнлэг үйлсийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн талаарх санал

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах төслийг тус тус боловсруулна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 2, 4, 6, 7, 9, 10, 12, 14 ДҮГЭЭР ЗҮЙЛД ДООР
ДУРДСАН АГУУЛГАТАЙ 2.1, 4.1.5, 6.11, 6.12, 7.8, 7.9, 7.10, 9.9, 9.10, 9.11, 9.12,
10.1.2, 10.3, 12.2, 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 14.2, 14.5, 14.9, 14.11, 14.12, 14.13
ДАХЬ ЗААЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСУГАЙ**

1 дүгээр бүлэг

1/2 дугаар зүйл. Ахмад настны хууль тогтоомж

2.1. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,” гэсний дараа “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль” гэж нэмэх.

1/4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.5. “насны хишиг” гэж 65, түүнээс дээш настай ахмад настанд олгох тэтгэмжийг;” гэснийг “насны хишиг” гэж 60, түүнээс дээш настай ахмад настанд олгох тэтгэмжийг;” гэж өөрчлөх.

1/6 дугаар зүйл. Ахмад настны эрх

“6.11. Ахмад настан арилжааны банкнаас тэтгэвэр барьцаалсан зээл авснаас хойш 3 сарын дараа нас барсан бол зээлийн үлдэгдэл үнийн дүнгийн 50 хүртэл хувийг нийгмийн даатгалын сангаас төлүүлэх эрхтэй.” гэж нэмэх.

“6.12. Ахмад настан хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосноос хойш 5 жилийн дотор нас барсан бол 2 жилийн тэтгэврийг, 5-10 жилийн дотор нас барсан бол 1 жилийн тэтгэврийг, 10 болон түүнээс дээш жилийн дараа нас барсан бол 6 сарын тэтгэврийг хууль ёсны өв залгамжлагчид нийгмийн даатгалын сангаас олгоно.” гэж нэмэх.

2 дугаар бүлэг

2/7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

“7.8. Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.1.1-т заасан төрлийн байгууллага шинээр байгуулсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад төрөөс 1 удаагийн дэмжлэг үзүүлж болно. Тухайн асуудлыг Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулна.” гэж нэмэх.

“7.9. Ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь бүсчилсэн байдлаар байна. Шинээр байгуулагдах байршил, хөрөнгө оруулалтыг Засгийн газраас тогтооно.” гэж нэмэх.

“7.10. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.16-д заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.” гэж нэмэх.

2/9 дүгээр зүйл. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

“9.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмад настныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангаж ажилласан бол татварын хөнгөлөлтөд хамрагдаж болно. Уг асуудлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар зохицуулна.” гэж нэмэх.

“9.10. Төрийн албаны тухай хуулийн 27.4-т заасан нөхцөл үүссэн бол ахмад настны мэргэжил, ур чадварыг харгалзан нийтийн алба болон төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллуулж болно.” гэж нэмэх.

“9.11. Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмад настны хүсэл, сонирхол, эрүүл мэнд, мэдлэг чадварт тохирсон хөдөлмөрийн харилцаа үүсгэж болохуйц аливаа ажлын байрны зар, мэдээлэл түгээхдээ насаар ялгаварлахыг хориглоно.” гэж нэмэх.

“9.12. Байгууллагын ахмадын зөвлөл нь байнгын орон тоотой, тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт зөвлөн туслах үүрэгтэй, тогтмол үйл ажиллагаа явуулна.” гэж нэмэх.

2/10 дугаар зүйл. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах

“10.1.2. ...магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч...” гэсний “...рашаан...” гэснийг хасах.

“10.3. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асран хамгаалж байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй гэр бүлийн гишүүн нийгмийн даатгалд хамрагдах асуудлыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулна.” гэж нэмэх.

2/12 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх, насны хишиг

“12.2. 65 болон түүнээс дээш...” гэснийг “12.2. 60 болон түүнээс дээш...” гэж өөрчлөх.

“12.3.1. 65-69 настай ахмад настанд тавин мянган төгрөг;” гэснийг “12.3.1. 60-69 настай ахмад настанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20 хувь;” гэж өөрчлөх.

“12.3.2. 70-79 настай ахмад настанд наян мянган төгрөг;” гэснийг “12.3.2. 70-79 настай ахмад настанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувь;” гэж өөрчлөх.

“12.3.3. 80-99 настай ахмад настанд нэг зуун тавин мянган төгрөг;” гэснийг “12.3.3. 80-89 настай ахмад настанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувь;” гэж өөрчлөх.

“12.3.4. 90, түүнээс дээш настай ахмад настанд хоёр зуун тавин мянган төгрөг.” гэснийг “12.3.4. 90, түүнээс дээш настай ахмад настанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувь;” гэж өөрчлөх.

4 дүгээр бүлэг

4/14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг

“14.2. ...насжилтын судалгааны төв,...” гэснийг “...насжилтын үеийн өвчний эрсдэлийг бууруулах,...” гэж өөрчлөх.

“14.5. Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан зарчим, эрхийг хангах зорилгоор ахмад настны тоон мэдээллийг нэгтгэн гаргах, түүнд тулгуурлан Засгийн газрын шийдвэр гаргуулах, биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ.” гэж нэмэх.

“14.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор олон нийтэд мэдээлнэ.” гэж нэмэх.

“14.11. Ахмадын сангийн хуримтлал үүсгээгүй, дэмжлэг үзүүлээгүй, олон нийтэд мэдээлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцно.” гэж нэмэх.

“14.12. Ахмад настны хөдөлмөрийн харилцаанд ялгаварлагдах, үл хайхрагдах, хүчирхийлэл, дарамтад өртөх явдлыг таслан зогсоох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг халамжийн болон гэр бүл хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.” гэж нэмэх.

“14.13. Их, дээд сургуулийн оюутны сургалтын хөтөлбөрт ахмад настны асрамжийн төвд сайн дурын ажил хийх, оролцоход кредит цаг тооцож болно. Энэ журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 27 ДУГААР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 27.4 ДЭХ ЗААЛТ НЭМСҮГЭЙ /Төсөл/

6 дугаар бүлэг

6/27 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилох

“27.4. Нийтийн алба болон төрийн үйлчилгээний албан тушаалын сонгон шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд мэргэжил, ур чадварыг нь харгалзан ахмад настныг томилон ажиллуулж болно.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 5 ДУГААР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 5.3.26 ДАХЬ ЗААЛТ НЭМСҮГЭЙ /Төсөл/

2 дугаар бүлэг.

**2/5 дугаар зүйл. Тусгай сан, түүний төрөл, тусгай санг шинээр байгуулах,
татан буулгах**

“5.3.26. Ахмадын сан.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 7, 21 ДҮГЭЭР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 7.2.7, 21.27, 29.9 ДЭХ ЗААЛТ НЭМСҮГЭЙ /Төсөл/

1 дүгээр бүлэг.

1/7 дугаар зүйл. Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ

“7.2.7. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асран хамгаалж байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй гэр бүлийн гишүүн.” гэж нэмэх.

3 дугаар бүлэг

3/21 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт

“21.27. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асран хамгаалж байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй гэр бүлийн гишүүн нийгмийн даатгалд хамрагдах бол тухайн үед мөрдөгдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.” гэж нэмэх.

3/29 дүгээр зүйл. Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх

“29.9. Ахмад настны тухай хуулийн 6.11, 6.12-т заасан нийгмийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 19.11 ДЭХ ЗААЛТ НЭМСҮГЭЙ /Төсөл/

4 дүгээр бүлэг

4/19 дүгээр зүйл. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.

“19.11. Ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэхээр шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн халамжийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН 23 ДУГААР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 23.1.15 ДАХЬ ЗААЛТ НЭМСҮГЭЙ /Төсөл/

5 дугаар бүлэг

5/23 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт.

“23.1.15. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.” гэж нэмэх.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..-р сарын .. өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 15,
22 ДУГААР ЗҮЙЛД ДООР ДУРДСАН АГУУЛГАТАЙ 15.1.16, 22.5.20 ДАХЬ ЗААЛТ
НЭМСҮГЭЙ /Төсөл/**

3 дугаар бүлэг

3/15 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал.

“15.1.16. Ахмад настны асрамжийн газар шинээр байгуулах, түүнд зориулсан тоног, төхөөрөмж, материал, ажиллах хүчний зардал.” гэж нэмэх.

6 дугаар бүлэг

6/22 дугаар зүйл. Албан татварын хөнгөлөлт.

“22.5.20. Ахмад настныг авч ажиллуулсан бол уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох тухайн төрлийн албан татварыг;” гэж нэмэх.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улс нийгмийн халамжийн багц хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдаж, мөрдөж эхэлсэн байдаг. Үүнээс хойш Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдаж 2024 оны 01 дүгээр саарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Мөн хуульд заасан бусад харилцааг зохицуулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудтай уялдуулан 2021 оны 12 дугаар сарын 16-нд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, 2022 оны 04 дүгээр сарын 22-нд ахмад настанд үзүүлэх дэмжлэг, ахмад настны ашиг сонирхлыг төлөөлөн хэрэгжүүлэх төрийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэг зэрэг харилцаанд өөрчлөлт орсон байна.

Зөвхөн нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж байсан урьдах хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл хүртээмжийг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг нэмж тусгасан байсан. Эдгээрээс гадна ахмад настантай холбоотой үйл ажиллагааг зохицуулсан Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиуд үйлчилж байна.

Түүнчлэн Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг төрөөс баталсан бодлогын баримт бичгүүдэд ахмад настны эрхийг хамгаалах асуудлыг тодорхой хэмжээнд тусгажээ.

Энэхүү хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд ахмад настныг нийгмийн идэвхтэй гишүүн байх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх, халамж, тэтгэмжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж, тэдгээрийг хэрэгжүүлж ирсэн ч ахмад настны өмнө тулгарч буй олон асуудлууд шийдлээ хүлээсээр байна.

Иймд дээр дурдсан хууль, тогтоомж, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Ахмад настны тухай хуулийн тэтгэврийн эрх шилжүүлэх тогтолцоо бүрдээгүй, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа атал хөдөлмөрийн үнэлэмжийг бодитойгоор үнэлээгүй, харьяалах байгууллагагүй

ахмад настны нэгдсэн бүртгэл судалгааг гаргахад хүндрэлтэй, нийгмийн хэрэгцээт үйлчилгээг авахад нь нэмэлт тусламж дэмжлэггүй, ахмадын сан байгуулах хуулийн хэрэгжилт хангалтгүй, рашаан сувилалд үйлчлүүлсэн нөхөн олговор зөрүүтэй, насны хишиг олгох насны хязгаар бусад хуультай нийцээгүй, инфляцын түвшинтэй уялдаагүй, асаргаа шаардлагатай ахмадын асран хамгаалагчийн асуудал хөндөгдөөгүй, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлага тодорхой бус байгаа харилцааг боловсронгуй болгох зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн уг төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 4 бүлэг, 17 зүйл, 79 заалтаас бүрдэх бөгөөд зарчмын шинжтэй дараах харилцааг зохицуулахаар тусгалаа.

Ахмад настны тухай хуулийн зорилт нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Нэгдүгээр бүлэгт ахмад настны хууль тогтоомжийн бүрдэл хэсэгт орхигдсон хууль тогтоомжийг нэмэх, жам ёсны эрхийг хангах үүднээс тэтгэвэр барьцаалсан зээлтэй нас барсан ахмад настны зээлийн эргэн төлөлт, тэтгэвэр тогтоолгоод удалгүй нас барсан ахмад настны тодорхой хувийг өв залгамжлагчид олгох асуудал, эдгээрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоох харилцааг тусгалаа.

Хоёрдугаар бүлэгт ахмадын асрамжийн үйлчилгээ үзүүлэх болон шинээр байгуулах аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, хэрэгцээ шаардлагад тулгуурлан аль нутаг дэвсгэрт байгуулах харилцааг тусгалаа.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх, төрийн албанд ахмад настны ур чадварыг харгалзан ажиллуулах, ажлын байрны ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, эрүүл мэндийг хамгаалах үүднээс асаргаа шаардлагатай ахмад настны асран хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох зохицуулалтыг тусгалаа.

Ахмад настанд үзүүлэх дэмжлэг, насны хишиг авах эрх 65 наснаас үүсэж байгаа зохицуулалтыг бусад хуультай нийцүүлэх, дэмжлэгийн хувь хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулсан байдлаар тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэгт ахмад настны тоон мэдээлэл хангалтгүй байдгаас шалтгаалан тэнд хүрч үйлчлэх үйлчилгээ дутмаг байгаа асуудал, төрөөс гарах шийдвэр, түүнд хяналт тавих тогтолцоог сайжруулах талаар тусгалаа.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасан ахмадын сан байгуулан ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, бусад хуультай зөрчилдөж байгаа асуудлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай нийцүүлэн тусгалаа.

Ахмад настны хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөж буй асуудлыг шийдэх зорилгоор соён гэгээрүүлэх, боловсролын хөтөлбөрт тусгуулах, эдгээр үйл ажиллагааг явуулах байгууллагын чиг үүргийг тодорхойлохоор тусгалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд асаргаа шаардлагатай ахмад настны асран хамгаалагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар, тэтгэвэр барьцаалсан зээлтэй болон тэтгэвэр тогтоолгоод удаагүй нас барсан ахмад настны тэтгэврийг өвлүүлэх санхүүжилтийн асуудлыг тусгалаа.

Нийгмийн халамжийн тухай хуульд ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэх шинээр байгуулагдсан байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн асуудлыг тусгалаа.

Төрийн албаны тухай хуульд ахмад настны ур чадварт тохирсон ажлын байраар хангах, хөдөлмөрлөх эрхийг нээх, төрөл хүртээмжийг нэмэгдүүлэх байдлаар тусгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байхаар тусгалаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төрөл, ангилалд “Ахмадын сан” байгуулах эрхийг нээж өгөх замаар тусгалаа .

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэхээр шинээр байгуулагдсан байгууллагад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах харилцааг тусгалаа.

-----oO-----